



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/394

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Онхотын булаг" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хуучин хөшөө дурсгалыг сэргээн засварлах ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

- Ажлын хэсгийн ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- Гишүүд: Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
- Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
- С.Батдорж - Аймгийн Архивын тасгийн дарга
- Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2. "Онхотын булаг" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Баярсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Б.ДӨЛГЭРСАЙХАН

8400 01 2016